



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 4/18

Булган сум

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 40 дүгээр зүйл, 39 дүгээр зүйлийн 39.1.2, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн эрхийн конвенцын 39 дүгээр зүйл, 40 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдүүдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсугай.

2.Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.


3.Хорооны үйл ажиллагаанд шаардагдах төсвийг жил бүр аймгийн төсөвт тусгаж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасан үүргийг хэрэгжүүлэн ажиллахыг хорооны дарга, аймгийн Засаг даргын орлогч (О.Ундрах), хорооны нарийн бичгийн дарга, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Оюунзаяа) нарт үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/64 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
01 дүгээр сарын 02-ны/ний өдрийн 01/02 дүгээр
захирамжийн хавсралт



Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн

Хүүхдийн эрхийн хууль зүйн
хорооны дарга:
Хорооны гишүүд:

Аймгийн Засаг даргын орлогч
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн дарга
Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг
зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн
дарга
Боловсролын газрын дарга
Эрүүл мэндийн газрын дарга
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын
дарга
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх
зүйн хэлтсийн дарга
Цагдаагийн газрын дарга
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга
Аймгийн ерөнхий прокурор
Шүүхийн тамгын газрын дарга
Булган аймгийн Өмгөөлөгчдийн холбооны дарга
Сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг
зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн
дарга нар
Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын
дарга

Нарийн бичгийн дарга: